



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 79

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт , 77.3 дахь хэсэг , аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2011 онд ашиглалтанд орсон 9,741,000 /Есөн сая долоон зуун дөчин нэгэн мянган/төгрөгийн балансын үнэ, 6,523,655.34/Зургаан сая таван зуун хорин гурван мянга зургаан зуун тавин таван төгрөг гучин дөрвөн/ мөнгөний үлдэгдэл өртөг хөрөнгийг Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Хорлоо, Ерөнхий боловсролын сургуулийн захирал М.Болормаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах:

2.2.Хөрөнгйн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх:

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР